



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 01 өдөр

Дугаар 9/01

Мандалговь

Г 2020 оныг "Иргэдийн ажиллаж, амьдрах
орчин нөхцөлийг сайжруулах жил" болгох тухай

Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын зорилт, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө", Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийг эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих, ажиллаж амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн үйлчилгээнд тэгш хүртээмжтэй хамрагдах, нийгмийн баталгааг нь сайжруулах зорилгоор 2020 оныг "Иргэдийн ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах жил" болгон зарласугай.


Хоёр. "Иргэдийн ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах жил"-ийн ажлыг орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

Гурав. Жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж, явцын тайланг 2020 оны 6,12 дугаар сарын 5-ны дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст ирүүлэхийг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

Дөрөв. "Иргэдийн ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах жил"-ийн ажлыг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн)-д, ажлын явц, үр дүнд хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Г.Самданцоодол)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



482010001

Аймгийн Засаг даргын 2020 оны
01.дүгээр сарын 22.-ны өдрийн 11..дугаар
захирамжийн хавсралт

**"ИРГЭДИЙН АЖИЛЛАЖ, АМЬДРАХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ
ЖИЛ"-ИЙН АЖЛЫГ ОРОН НУТАГТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН
БҮРЭЛДХҮҮН**

- Дарга:
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Гишүүд:
- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
 - Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
 - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
 - Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
 - Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга
 - Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
 - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
 - Мэргэжлийн хяналтын газрын дарга
 - Эрүүл мэндийн газрын дарга
 - Сайнцагаан сумын Засаг дарга
- Нарийн бичгийн дарга:
- Нийгмийн бодлогын хэлтсийн дарга